Төсөл

Засгийн газрын 2026 оны ...дугаар
сарын ....-ний өдрийн .... дугаар
тогтоолын хавсралт

АЖЛЫН БАЙРАН ДАХЬ АСБЕСТИЙН ӨРТӨЛТӨӨС АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХАД МӨРДӨХ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Нэг. Ерөнхий зүйл

1.1.Зорилго, хамрах хүрээ

1.1.1.Энэ техникийн зохицуулалтаар ажлын байран дахь асбесттай аюулгүй харьцах болон ажилтны эрүүл мэндийг асбесттай холбоотой өвчнөөс хамгаалах урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх нийтлэг шаардлагыг тогтооно.

1.1.2.Энэ техникийн зохицуулалтыг асбест, асбест агуулсан материал болон хаягдалтай харьцдаг үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага ажилтныхаа эрүүл мэндийг хамгаалах, асбестаас үүдэлтэй мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаанд заавал мөрдөнө.

1.1.3.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3.1.4 дүгээр зүйлд заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага асбест болон асбест агуулсан материалыг зөвхөн зөвшөөрсөн газарт, тогтоосон зориулалт, хэмжээ, технологийн шаардлагын дагуу хэрэглэнэ.

1.2.Норматив эшлэл

1.2.1.Энэ техникийн зохицуулалтад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ:

-MNS 4990.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисын хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага, зөвшөөрөгдөх дээд хэмжээ.

-MNS ISO 10312.Орчны чанар- Асбестийн ширхэглэгийг тодорхойлох. Нэвт дамжуулах электрон микроскопын арга

-MNS ISO 8672.Агаарын чанар. Ye шатаар ялгах оптик микроскопоор агаар дахь органик бус ширхэглэгийн тоон концентратыг тодорхойлох- Хальсан шүүлтүүрийн арга

-MNS ISO 22262-2:2015.Агаарын чанар- Бүхэл материалууд. Хоёрдугаар хэсэг: Асбестийн ширхэглэгийг жингийн болон микроскопын аргаар тоолж тодорхойлох

-MNS 6654. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл. Амьсгал хамгаалах хэрэгслийн сонголт, хэрэглээнд тавих ерөнхий шаардлага

1.3. Нэр томьёо, тодорхойлолт

Энэ техникийн зохицуулалтад хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.”асбест” гэж хүнд уушги тоосжих өвчин (асбестоз), уушгины хавдар, гялтан хальсны хавдар (мезотелиома) зэрэг өвчин үүсгэдэг, нүдэнд үзэгдэхгүй маш нарийн утаслаг ширхэглэгт тоос ялгаруулдаг (кризотил, амозит, крокидолит, тремолит, антофиллит, актинолит) асбестийн эрдсийн бүлгийг;

1.3.2.”асбест агуулсан материал” гэж нэг хувиас илүү асбестийн агууламжтай бүх төрлийн материалыг;

1.3.3.”өндөр эрсдэлтэй I ангиллын ажил” гэж 7,5 м-ээс урт шугам хоолой эсвэл 1 м.кв -аас их талбайтай барилгын хийцээс бутрамхай шинжтэй асбест агуулсан материалаар хийгдсэн дулаалга, тусгаарлалтыг засварлах, хуулах, зайлуулах, засварлах зэрэг асбест

агуулсан тоос, хог хаягдал ихээр ялгаруулж, ажил гүйцэтгэж байгаа ажилтан болон ойр хавийн бусад хүмүүст асбестийн өртөл ихээр үүсгэх эрсдэлтэй ажлыг;

1.3.4.”өндөр эрсдэлтэй II ангиллын ажил” гэж гэж 7,5 м-ээс богино шугам хоолой эсвэл 1 м.кв-аас бага талбайтай барилгын хийцэд харьцангуй бага бутрамхай шинжтэй асбест агуулсан материалаар хийгдсэн дулаалга, тусгаарлалтыг засварлах, хуулах, зайлуулах, засварлах асбест агуулсан тоос, хог хаягдал ялгаруулж, ажил гүйцэтгэж байгаа ажилтан болон ойр хавийн бусад хүмүүст асбестийн өртөл ихээр үүсгэх эрсдэлтэй ажлыг;

1.3.5.”дунд эрсдэлтэй ажил” гэж бутрамхай шинж багатай асбест агуулсан материалаар хийгдсэн барилгын жижиг хэмжээтэй хийц, дулааны шугам хоолой засвар хийх зэрэг асбест агуулсан тоос, бутрамхай бус хаягдал богино хугацаанд бага хэмжээгээр ялгаруулдаг ажил гүйцэтгэж байгаа ажилтнуудад эрсдэлтэй ажлыг;

1.3.6.”бага эрсдэлтэй ажил*”* гэж өндөр, дунд эрсдэлтэй ажлын үед үүссэн тоос, хог хаягдал, үйрмэгийг цэвэрлэх болон асбест агуулсан материалын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр засвар үйлчилгээ хийх зэрэг эрсдэл багатай ажлыг;

1.3.7.”техник технологийн урьдчилан сэргийлэлт” гэж ажлын байран дахь асбестийн бохирдол, ажилтны асбестэд өртөх эрсдэлийг бууруулах, орчинд тархахаас сэргийлэх зорилгоор битүүмжилсэн тусгаарлалт, агааржуулалтын систем, аэорозол хөшиг үүсгэх, хаалт, бээлийтэй уут зэрэг техникийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг;

1.3.8.практик арга гэж ажлын байранд өдөр тутам мөрдөх асбест агуулсан материал, гадаргууг норгож тоос дарах, тоос бага үүсгэх, ХЕПА шүүлтүүртэй агааржуулалт, тоос сорогч ашиглах зэрэг арга барилаар ажиллаж асбестийн бохирдлыг бууруулах болон хориглосон үйлдлийг хийхгүй байх зан үйл, дэглэмийг;

1.3.9.битүүмжилсэн тусгаарлалт гэж асбесттай харьцах ажлын байрнаас орчинд асбестийн ширхэглэг тархахаас сэргийлэх зорилгоор ажлын байрыг битүү хучиж, нэг болон олон давхаргат хуванцар эдэн бүрхүүлээр битүүмжилсэн орчин үүсгэсэн түр байгууламж;

1.3.10.бээлийтэй уут гэж 150х150 см-ийн хэмжээтэй гаднаасаа дотогшоо орсон бээлийтэй, дотор талдаа асбест агуулсан бүтээгдэхүүнтэй харьцаж ажиллаж болох хангалттай зайтай, бэхжүүлсэн хуванцар эдэн уутыг;

1.3.11.цэвэрлэгээний өрөө гэж нэг талаараа асбесттай харьцах ажлын байртай холбогдсон, тоног төхөөрөмжийн тасалгаа, усанд орох тасалгаа, цэвэр тасалгаанаас бүрдсэн түр байгууламж;

1.3.12.”ХЕПА шүүлтүүр” (high efficiency particulate air filter) гэж агаарт тархсан 0.3 мкм-ээс том хэмжээтэй тоосонцрыг 99.97 хувийн үр ашигтай шүүж, цэвэрлэдэг өндөр үр ашигтай агаарын шүүлтүүрийг хэлнэ.

Хоёр.Асбесттай харьцах аюулгүй ажиллагааны ерөнхий зарчим

2.1.Аж ахуйн нэгж байгууллага, иргэн эзэмшдэг эсхүл ашигладаг барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн байгууламжид нь асбест агуулсан материал ашигласан бол буулгах, засварлах, өргөтгөх зэрэг ажлын үед ажил гүйцэтгэх ажилтныг асбестийн сөрөг нөлөөллөөс хамгаалах зорилгоор бүртгэл хөтөлж, холбогдох ажил олгогч, бусад талд мэдэгдэх үүрэгтэй.

2.2.Ажил олгогч асбест агуулсан материал, хог хаягдалтай харьцах ажил гүйцэтгэх үед урьдчилан сэргийлэх арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлнэ:

2.2.1.ажлын байранд дахь асбест агуулсан байршил, өртөлт үүсгэх магадлалтай эх үүсвэрийг тогтоож, бүртгэл хөтлөх;

2.2.2. ажлын байрны агаар дахь асбестийн бохирдлын түвшин, ажилтны асбестэд өртөх хэмжээг хянах;

2.2.3.эрсдэлийн түвшнээс хамааран хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.2.4.ажлын дараа цэвэрлэгээ, ариутгал хийж, хог хаягдлыг зайлуулах

2.2.5.ажилтны эрүүл мэндийн тандалтыг хэрэгжүүлэх;

2.3.Асбесттай харьцах ажлыг тогтмол эсвэл давтамжтай гүйцэтгэдэг ажил олгогч нь энэхүү техникийн зохицуулалтын шаардлагад нийцүүлэн асбесттай харьцах аюулгүй ажиллагааны талаарх журмыг боловсруулж, мөрдөнө. Асбесттай харьцах аюулгүй ажиллагааны журам нь дараах агуулгатай байна:

2.3.1.ажил олгогч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд(ХАБЭМ)-ийн ажилтан, ажил гүйцэтгэх ажилтан,тэдний удирдлага, туслан гүйцэтгэгч, ойролцоо ажилладаг бусад ажилтны үүрэг, хариуцлагыг тодорхойлно;

2.3.2.барилга, байгууламж дахь асбест агуулсан материал, хийцийг тодорхойлж, байршил, төлөв, тоон хэмжээ, бутрамхай байдлыг бүртгэх, бүртгэлийг шинэчлэн хөтлөх;

2.3.3.ажил гүйцэтгэхээс өмнө болон дараа ажлын байрны агаарт асбестийн суурь бохирдол тодорхойлох, ажлын явцад ажилтны өртөлтийг тодорхойлох үнэлгээ;

2.3.4.асбесттай харьцах ажлын үед эрсдэлийн түвшнээс хамааран хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэлт, хамгаалалтын арга хэмжээ;

2.3.5.ажилтнуудад зориулсан асбестийн сөрөг нөлөөллийн талаар ойлголт мэдлэг олгох, харьцаа аюулгүй ажиллагааны дадал эзэмшүүлэх сургалт, зааварчилгаа;

2.3.6.ажилтны эрүүл мэндийн тандалт: Өндөр, дунд эрсдэлийн ангиллын ажил гүйцэтгэдэг ажилтнуудад хийх эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт, хугацаат үзлэг болон ажлаас чөлөөлөгдөх үеийн үзлэгийг зохион байгуулна;

2.3.7. санамсаргүй эсвэл ослын улмаас асбестийн утаслаг бүхий тоос агаарт хяналтгүйгээр цацагдсан үед хэрэгжүүлэх арга хэмжээ,

i. ажлын талбайн тусгаарлалт, нүүлгэн шилжүүлэлт, ,

ii. асбесттай холбоотой осол, зөрчил, бохирдлын талаарх мэдээлэл хүлээн авах, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн хяналт, эрх бүхий байгууллагад мэдэгдэх,

iii. асбестэд өртсөн ажилтанд холбогдох

iv. асбестийн аюул, эрсдэл, аюулгүй ажиллагаа, асбестийн бохирдлын үед цэвэрлэгээ хийх талаар тусгай сургалт, зааварчилгаанд хамрагдсан сургагдсан ажилтнаар цэвэрлэгээний ажил гүйцэтгүүлэх;

2.3.8.асбесттай харьцах ажилд хамааралгүй туслан гүйцэтгэгч болон бусад тал ажлын талбайд нэвтрэхтэй холбоотой зохицуулалт, асбест агуулсан материалын хагалж, бутлахаас сэргийлэх арга хэмжээ асбесттай харьцах ажил гүйцэтгэх эрх бүхий туслан гүйцэтгэгч;

2.4.Асбесттай харьцах аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтийн ажил олгогч өөрөө эсхүл асбестийн аюул, эрсдэл, асбесттай аюулгүй харьцах, асбестийн бохирдлын үед авах арга хэмжээний талаар холбогдох сургалтад хамрагдсан, мэдлэг, ур чадвар эзэмшсэн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий ажилтныг томилж хариуцуулна.

2.5.Ажил олгогч нь асбесттай харьцах аюулгүй ажиллагааны журмыг боловсруулах, хэрэгжүүлэхдээ мэргэжлийн байгууллага болон мэргэшсэн мэргэжилтнээс гэрээт үйлчилгээ авч болно.

Гурав. Өртөлтийн үнэлгээ

3.1.Асбесттай харьцах өндөр эрсдэлтэй ажлыг гүйцэтгэхээс өмнө болон дараа ажлын байрны агаараас асбестийн сорьцыг 30 минутаас багагүй хугацаанд цуглуулж, MNS 4990 стандартад заасан цагт жинлэсэн дундаж өртөлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулан үнэлнэ.

3.2.Асбесттай харьцах ажил гүйцэтгэсний дараа ажлын байрны агаар дахь асбестийн утаслаг ширхэглэгийн концентраци, ажил эхлэх үеийн түвшнээс хэтрээгүй байх ёстой. Хэрэв хэтэрсэн тохиолдолд ажлын байрны цэвэрлэгээг дахин хийж, хэмжилтийг давтана гүйцэтгэнэ.

3.3.Асбесттай харьцах бүх төрлийн ажлын явцад хувь хүний амьсгалын түвшнээс ажлын 8 цаг болон 30 минутын хугацаанд сорьц цуглуулж, асбестийн утаслаг ширхэглэг тодорхойлох шинжилгээг ажилтны өртөлтийг өдөр тутам хянана.

3.4.Хувь хүний сорьц цуглуулалтаар ажилтны өртөлт MNS 4990 стандартад заасан цагт жинлэсэн дундаж болон богино хугацааны өртөлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэхгүй. Хэтэрсэн тохиолдолд асбестийн өртөлтийг бууруулах тохирох хамгаалах арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлнэ.

3.5.Ажлын байрны агаар болон ажилтны амьсгалын түвшнээс асбестийн сорьц цуглуулж, шинжлэхэд MNS ISO 8672, MNS ISO 10312 стандарт, эдгээртэй дүйцэх аргыг ашиглана.

3.6.Ажил гүйцэтгэх үед статистикийн ач холбогдолтой буюу 6-аас цөөнгүй тооны сорьцод хийсэн шинжилгээгээр ажилтны асбестийн өртөлт цагт жинлэсэн дундаж болон богино хугацааны өртөлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй бол өдөр тутам хийх ажилтны өртөлтийн үнэлгээг зогсоож болно.

3.7.Ажил олгогч ажилтны өртөлтийг тодорхойлсон лабораторийн шинжилгээний үр дүнг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаж асбестийн нөлөөлөлд өртсөн ажилтан эсвэл ажилтны төлөөлөлд мэдэгдэнэ.

3.8.Асбесттай харьцах ажил гүйцэтгэж буй ажлын байрны ойролцоо ажиллаж байгаа ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх зорилгоор ажил гүйцэтгэх болон дараа, ажлын явцад агаарт асбестийн утаслаг ширхэглэг тодорхойлох сорьц цуглуулж болно.

3.9.Асбестийн бохирдол бүхий ажлын байранд сорьц цуглуулалт, мониторинг хийх мэргэжилтэн энэ техникийн зохицуулалтын 6-р хэсэгт заасны дагуу өндөр эрсдэлтэй I ангиллын ажил гүйцэтгэхэд шаардлагатай хамгаалах хувцас, хэрэгслийг хэрэглэж, аюулгүй ажиллагааны журмыг дүрмийг мөрдөнө.

Дөрөв . Асбесттай харьцах ажлын үед мөрдөх урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээ

4.1.Асбесттай харьцдаг бүх төрлийн ажлын үед өртөлтийн түвшнээс үл хамааран дараах урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг мөрдөж ажиллана:

4.1.1.энэ техникийн зохицуулалтын 3.1-д заасан аюулгүй ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна.

4.1.2.ажлын үед үүссэн асбест агуулсан тоос, үйрмэгийг ХЕПА шүүлтүүртэй тоос сорогчоор соруулж, цэвэрлэх;

4.1.3.асбест агуулсан материалтай харьцах, холих, зайлуулах, тастах, цэвэрлэгээ хийхэд үед тоос дарах зорилгоор норгох, чийглэх;

4.1.4.асбестийн бохирдол бүхий хог хаягдлыг битүү сав, шүүрч, нэвчихгүй уутанд цуглуулан нэн даруй зайлуулна.

4.1.5.ажилтны өртөлтийг MNS 4990 стандартад богино хугацааны болон цагт жинлэсэн дундаж өртөлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах зорилгоор дараах хяналтын арга хэмжээг хэрэгжүүлнэ:

i.тоос үүсгэж буй эх үүсвэрт ХЕПА шүүлтүүртэй хэсгийн татах агааржуулалтыг ашиглах;

ii.асбестийн тоос үүсгэж буй ажлын процесс, тоног төхөөрөмжид битүүмжлэл, тусгаарлалт хийх;

iii.ажлын байрны ерөнхий агааржуулалтаар зайлуулагдах агаарын урсгал ажилтны амьсгалын бүсээс ХЕПА шүүлтүүртэй агаар сорох төхөөрөмж рүү чиглэсэн байх;

iv.хөдөлмөрийн эрүүл ахуйн практикт хүлээн зөвшөөрөгдсөн бусад хяналтын арга хэмжээг ашиглах;

v.эдгээр хяналтын арга хэмжээгээр ажилтны өртөлтийг MNS 4990 стандартад заасан цагт жинлэсэн дундаж өртөлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага түвшинд

бууруулж чадахгүй бол энэхүү техникийн зохицуулалтад заасан шаардлагын дагуу амьсгал хамгаалах хэрэгслийг хэрэглүүлнэ.

4.1.6.асбесттай харьцах ажлын үед дараах үйлдэл гаргахыг хориглоно:

i.ХЕПА шүүлтүүртэй тоос сорогчоор тоноглогдоогүй их эргэлтийн хурдтай цахилгаан хөрөө ашиглах;

ii.асбест агуулсан материалыг зайлуулахдаа даралтад агаараар үлээлгэх;

iii.асбест агуулсан тоос, үйрмэгийг норгож чийглэхгүйгээр хуурайгаар нь шүүрдэх, хүрздэх, бусад хуурай аргаар цэвэрлэх;

iv.асбесттай харьцдаг ажил хийдэг ажилтны өртөлтийг бууруулах зорилгоор өөр ажилтны сэлгүүлж ажиллуулах.

4.2.Өндөр эрсдэлтэй I ангиллын ажлыг гүйцэтгэхэд дараах практик арга, техник технологийн урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.2.1.асбестийн өртөлтийг арилгах, бууруулах, тусгаарлах техник технологийн шийдлийг суурилуулж, түүний хэвийн ажиллагааг хариуцах ажилтан нь асбестийн аюулгүй ажиллагаагаар мэргэшсэн байна.

4.2.2.ажлын байранд асбестийн концентраци зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүйг хэмжилтээр тогтоогоогүй бол дараах аргуудаас аль тохиромжтойг нь сонгож асбестийн бохирдлыг ажлын байрнаас гадагш алдагдахаас сэргийлнэ:

i.ажлын байрнаас агаар гарч болох бүх гарц, хаалга, гарц, цонх, агааржуулалт зэргийг бүрэн хааж, битүүмжилнэ. Гадаад орчинд хийгдэх ажилд энэ заалт хамаарахгүй.

ii.дээрхээс гадна хаалт, тусгаарлалтын өөр төрлийн аргын нэмэлтээр хэрэглэж, асбестийн бохирдлыг алдагдахаас сэргийлж болно.

iii.хаалт, битүүмжлэлийн гаднах агааранас сорьц цуглуулж, асбестийн ширхэглэгийн бохирдолд хяналт тавих ба ажил эхлэхээс өмнөх суурь бохирдлыг түвшнээс хэтэрсэн тохиолдолд ажлыг зогсоож, битүүмжлэлийг хангана.

iv.битүүмжилсэн ажлын байранд ашиглах агааржуулалтын системийг 0.1524 мм зузаантай давхар пластик эсвэл үүнтэй дүйцэхүйц материалаар битүү ороож бохирдол орохоос сэргийлнэ.

v.ажлын байрны шалыг ус нэвтэрдэггүй материал бүрхэж дэвсэх ба талбай доторх эд зүйлсийг ус нэвтэрдэггүй материалаар бүтээж, завсрыг нь наалддаг туузаар битүүмжилнэ.

vi.ажилтны өртөлт Зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн нь хэмжилтээр тогтоогдсон бол ажилтны амьсгалын бүсээс асбестийн бохирдлыг зайлуулах ХЕПА шүүлтүүртэй агааржуулалтын төхөөрөмж ашиглана.

4.2.3.өндөр эрсдэлтэй I ангиллын ажлыг гүйцэтгэхэд техник технологийн урьдчилан сэргийлэлтийн дараах өвөрмөц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

i.***сөрөг даралттай битүүмжилсэн тусгаарлалтыг*** ажлын байр, ажлын онцлогт нийцүүлэн байгуулна. Тусгаарлалтын байгууламжид, агааржуулалтын төхөөрөмж ашиглан тогтмол сөрөг даралт үүсгэх ба гаднах орчны агаарын даралтаас -0.02 инч усны баганаас ихгүй байна. Сөрөг даралтыг манометрээр хэмжилт хийж хянана. Тусгаарлалт доторх агаарыг цагт 4-аас доошгүй удаа сэлгэх ба зайлуулах агаарын урсгал чиглэл ажилтнаас агаар цуглуулах төхөөрөмж рүү чиглэсэн байна. Агааржуулалтын төхөөрөмж асбестийн бохирдлыг шүүж цэвэрлэх ХЕПА шүүлтүүртэй байна. Ажил эхлэхээс өмнө тусгаарлалтын битүүмжлэлийг шалгаж урагдсан, цоорсон байвал битүүлнэ.

ii.шугам хоолой, булан тохой, холбоос, барилгын хийц зэрэг жижиг талбайд ажил хийх 6 мил зузаантай пластик материалаар хийгдсэн **бээлийтэй уут** ашиглана. Бээлийтэй уут ёроолгүй нээлттэй байх тэр хэсгээр нь шугам хоолой зэрэг ажил хийх дээр суурилуулж, зай завсрыг битүүлж нааж, ажил эхлэхээс өмнө утаат сорилоор шалгана. 65 цельсийн хэмээс их халуунтай гадаргуу дээр хэрэглэхгүй. Бээлийтэй уутыг зөвхөн нэг удаа хэрэглэх ба ажлын дараа хуулж авахаас өмнө доторх агаарыг ХЕПА шүүлтүүртэй тоос сорогчоор цэвэрлэнэ.

Ажил эхлэхээс өмнө зэргэлдээ задарч гэмтсэн асбест агуулсан гадаргууг 0.1524 мм зузаантай пластик материалаар ороож битүүмжилнэ. Бээлийтэй уутыг хаягдлын ууттай хоолойгоор холбоно. Хаягдлын уут болон бээлийтэй уутыг гүйдэг таг, хавхалгаар тусгаарлаж, бохир уутыг солих, салгах үед асбестийн тоос орчинд тархахаас сэргийлнэ. Ажлын үед бээлийтэй уут цоорох, урагдахаас сэргийлнэ. Бээлийтэй ууттай ажиллах бол хоёроос цөөнгүй хүн ажиллана.

iii.шугам хоолойгоос асбест зайлуулахад ХЕПА шүүлтүүртэй тоос агаар сорох төхөөрөмж холбосон **сөрөг даралттай бээлийтэй уутыг** ашиглаж болох ба бээлийтэй уут ашиглахтай нэг адил шаардлагыг мөрдөнө. 0.1524 мм зузаантай пластик материалыг давхарлах, агаар шүүх төхөөрөмж ашиглах шаардлага нэмэлтээр тавигдана.

iv.асбестийн аюулгүй ажиллагааны сургалтаас гадна ус шүршиж хаалт үүсгэх талаарх сургалтад хамрагдсан ажилтан ажил гүйцэтгэх бол **ус шүршилтийн аргыг** ашиглаж болно. Гурван талт хүрээтэй, даралтат усыг 360 хэмээр тоосруулан шүршиж, ажилтан болон асбест агуулсан материал хийцийн хооронд аэрозолын хөшиг үүсгэнэ. Энэ төхөөрөмжийг ашиглахаас өмнө 10 минутын өмнө ажиллуулах ба гурваас цөөнгүй хүн хамт ажиллана. Нэг ажилтан нь шүрших төхөөрөмж хэвийн ажиллаж буйд хяналт тавина.

v.хоёроос илүү хүн багтах боломжгүй зай талбайтай нөхцөлд асбест зайлуулах бол жижиг оврын битүүмжилсэн тусгаарлалт ашиглана. Тусгаарлалтыг 0.1524 мм зузаантай пластик материалаар хийж, ХЕПА шүүлтүүртэй агаар сорох эсвэл агааржуулалтын төхөөрөмжтэй ашиглаж сөрөг даралтай үүсгэнэ. Ажил эхлэхээс өмнө битүүмжлэлийг шалгаж, утаат сорил хийнэ. Дахин ашиглах тохиолдолд тоосыг нь соруулж, угааж цэвэрлэнэ. Агааржуулалтын урсгал ажилтнаас агаар цуглуулах төхөөрөмж рүү чиглэсэн байна.

4.2.4.өндөр эрсдэлтэй I ангиллын ажлын үед техник технологийн урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээ ажилтны өртөлтийг Зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, ажлын талбайн гаднах бохирдлоос сэргийлж чадаж буйд эсэхийг хэмжилтээр тодорхойлж, хяналт тавина.

4.3.Өндөр эрсдэлтэй II ангиллын ажлыг гүйцэтгэхэд дараах мөрдөх практик арга, техник технологийн урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.Үүнд:

4.3.1.барилга байгууламж дотор хийгдэх ажлын үед сөрөг даралттай тусгаарлалт хийгээгүй болон ажилтны өртөлтийн Зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэх нөхцөл үүсэж болзошгүй тохиолдолд ажлын байрнаас асбестийн бохирдол тархахаас сэргийлж дараахыг хэрэгжүүлнэ:

i.ажил гүйцэтгэх талбайн задгай бүх хэсгийг битүүлэн хаалт хийх эсвэл ажлын талбайгаас асбестийн бохирдол алдагдахаас сэргийлсэн тусгаарлалт хийж, үр дүнг нь хэмжилтээр баталгаажуулах;

ii.ажлын байрны хийц, эд зүйлсийн гадаргууг нэвтэрдэггүй материалаар хучих;

iii.энэ техникийн зохицуулалтын 5.1-д заасан арга хэмжээг мөрдөх.

4.3.2.өндөр эрсдэлтэй II ангиллын ажлын үед хэрэглэх инженерийн хяналтын арга хэмжээг ашиглаж болно.

4.4.Дунд эрсдэлтэй ажлыг гүйцэтгэхэд мөрдөх практик арга, техник технологийн урьдчилан инженерийн урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.Үүнд:

4.4.1.асбест агуулсан материал, гадаргууг чийглэж, норгох;

4.4.2.тоос үүсгэж буй эх үүсвэрт тохиромжтой загварын хэсгийн татах агааржуулалтыг ашиглах;

4.4.3.асбест агуулсан дулаалга, материалыг өрөмдөх, тастах, зүлгэх, цоолох, хаглах, бутлах зэрэг бүрэн бүтэн байдлыг алдагдуулж, тоос үүсгэх ажлыг хийхдээ 5.2-д заасан жижиг оврын битүүмжилсэн тусгаарлалт эсвэл бээлийтэй уут, бусад тусгаарлалтын аргыг ашиглах;

4.4.4. ажилтны өртөлт Зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүйг хэмжилтээр тогтоогоогүй бол 5.2-д заасны дагуу битүүмжилсэн тусгаарлалт, хаалтыг хийнэ.

4.5.Бага эрсдэлтэй ажлыг гүйцэтгэхэд дараах практик арга, техник технологийн урьдчилан сэргийлэлтийг мөрдөнө.Үүнд:

4.5.1.энэ техникийн зохицуулалтын 5.1-д заасан нийтлэг шаардлагыг мөрдөх;

4.5.2.ажлын талбайд асбест агуулсан тоос, хаягдлыг цэвэрлэх үед амьсгал хамгаалах хэрэгслийг 6.3-д заасны дагуу хэрэглэнэ.

4.4.3.ажлын байран дахь дулаалгын материал, бусад бутрамхай материалыг асбест агуулсан гэж үзэж хог хаягдлыг нь зайлуулна.

Тав. Ажлын тусгай хувцас, амьсгал хамгаалах хэрэгсэл

5.1.Өндөр эрсдэлтэй I ангиллын ажлын үед ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг дараах шаардлагын дагуу олгож, зохистой хэрэглээнд нь хяналт тавина. Үүнд:

5.1.1.ажилтны бүх биеийг бүрхсэн өмсгөл (cover-all), хамгаалах дуулга, ажлын бээлий, хамгаалах гутал, ус нэвтрүүлдэггүй гутлын уут зэрэг ажлын байрны нөхцөлд тохирсон ажлын тусгай хамгаалах хувцсаар ажилтныг хангах;

5.1.2.MNS 6654 стандартын дагуу тохирсон амьсгал хамгаалах хэрэгслийг олгох;

5.1.3.асбесттай харьцдаг ажилтны бохирдсон ажлын хувцсыг түр хадгалах, зөөвөрлөхдөө чийг, тоос нэвтрүүлдэггүй уут, битүү саванд хийж, анхааруулах шошго наах;

5.1.4.асбесттай харьцаг ажилтны ажлын хувцсыг угаахаас өмнө ХЕПА шүүлтүүртэй тоос сорогчоор хувцас дээрх тоосыг соруулж, цэвэрлэх;

5.1.5.асбесттай харьцдаг ажилтны хувцсыг бусад ажилтны хувцастай хамт угаахыг хориглох, тусад нь угаах;

5.1.6.ажлын үед хамгаалах хувцасны бүрэн бүтэн байдлыг өдөрт нэгээс цөөнгүй удаа шалгаж, урагдаж, цоорч гэмтсэн бол нэн даруй битүүмжлэх эсвэл солих.

5.2.Өндөр эрсдэлтэй II ангиллын ажлын үед ажилтны өртөлт Зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүйг хэмжилтээр тогтоогоогүй, асбест агуулсан материалын бүрэн бүтэн байдлыг алдуулан харьцаж ажиллах үед энэ техникийн зохицуулалтын 6-д заасан ажилтанд ажлын тусгай хувцас, амьсгал хамгаалах хэрэгслийг шаардлагын дагуу олгож, зохистой хэрэглээнд нь хяналт тавина.

5.3.Дунд эрсдэлтэй ажлын үед ажилтны өртөлт Зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүйг хэмжилтээр тогтоогоогүй болон асбест агуулсан материалын бүрэн бүтэн байдлыг алдуулах ажлын тоос дарах нойтон аргыг ашиглаагүй тохиолдолд MNS 6654 стандартын дагуу амьсгал хамгаалах хэрэгслийг шаардлагын дагуу олгож, зохистой хэрэглээнд нь хяналт тавина.

5.4.Бага эрсдэлтэй ажлын үед ажилтны хийж ажлын бусад шаардлагын улмаас амьсгал хамгаалах хэрэглэх тохиолдолд MNS 6654 стандартын дагуу олгож, зохистой хэрэглээнд нь хяналт тавина.

5.5.Асбесттай харьцдаг бүх төрлийн ажил гүйцэтгэдэг ажилтны ажлын хувцсыг цэвэрлэх, хадгалахад энэ техникийн зохицуулалтын 6.5.3-6.5.5-д заасан шаардлагыг биелүүлнэ.

5.6.Асбесттай харьцах ажлын амьсгал хамгаалах хэрэгслийн хэрэглээнд дараах ерөнхий шаардлагыг мөрдөнө. Үүнд:

5.6.1.энэ техникийн зохицуулалтын шаардлагын дагуу болон сайн дурааараа хүсэлт гаргасан ажилтан бүрийг тохирсон амьсгал хамгаалах хэрэгслээр хангаж, зөв хэрэглэх сургалт, зааварчилгаагаар хангах;

5.6.2.эрүүл мэндийн үзлэг, амьсгал хамгаалах хэрэгслийн тохирооны сорилоор ажилтан амьсгал хамгаалах хэрэгсэл хэрэглэх боломжгүй нь тогтоогдвол ажилтныг эрсдэлгүй өөр ажилд шилжүүлэх;

5.6.3.амьсгал хамгаалах хэрэгслийн сонголт, хэрэглээнд MNS 6654 стандартыг мөрдөх;

5.6.4.асбестийн өртөлтөөс хамгаалахад шүүлтүүрэн маск хэрэглэхийг хориглоно.

Тайлбар: асбестийн утас ширхлэг нь маш нарийхан, жижиг хэмжээтэй тул ердийн тоосноос хамгаалах зориулалтын N95, FFP2 зэрэг шүүлтүүрэн маскт шүүгддэггүй.

5.6.5.өндөр эрсдэлтэй I ангиллын ажлын үед 8 цагт жинлэсэн дундаж өртөлтийн түвшин 1 ш/см^3-аас ихгүй нөхцөлд ажилтанд ХЕПА шүүлтүүр бүхий битүүмжлэл сайтай хөдөлгүүрт агаар цэвэршүүлэгч, бүтэн нүүрэвчтэй, даралт-хэрэгцээний горимтой агаарын хангамжтай амьсгал хамгаалах хэрэгсэл эсхүл агаар нөөцлөгчтэй амьсгалын аппаратаас сонгож, хэрэглүүлнэ.

5.6.6.өндөр эрсдэлтэй I ангиллын ажлын үед 8 цагт жинлэсэн дундаж өртөлтийн түвшин 1 ш/см^3-аас хэтэрсэн нөхцөлд ажилтанд нэмэлт цилиндртэй, агаар нөөцлөгчтэй амьсгалын аппаратыг ашиглана.

5.6.7. өндөр эрсдэлтэй II ангиллын болон дунд эрсдэлтэй ажлын үед ажилтанд хагас нүүрэвчтэй амьсгал хамгаалах хэрэгслийг хэрэглүүлнэ.

Зургаа.Ажлын байранд мөрдөх эрүүл ахуйн шаардлага

6.1.Асбесттай харьцах бүх төрлийн ажил хийгдэж буй ажлын байранд тамхи татах, хоол идэх, унд уух, бохь зажлахыг хориглоно.

6.2.Асбесттай харьцах ажлын үед ажилтан үдийн хоол идэх, унд уух зориулалтын асбестийн бохирдолгүй талбайгаар хангана.

6.3.Асбесттай харьцах ажил хийдэг ажилтан үдийн хоол идэхээс өмнө асбестийн бохирдолтой ажлын хувцас, хамгаалах хэрэгслээ энэ техникийн зохицуулалтын шаардлагын дагуу цэвэрлэх эсхүл сольсон байна.

6.4.Ажлын багаж, тоног төхөөрөмж, савыг тоног төхөөрөмжийн тусгаарлалтын байгууламж, ажлын байрнаас гаргахаас өмнө цэвэрлэсэн байна.

6.5.Өндөр эрсдэлтэй I ангиллын ажил гүйцэтгэх дараах эрүүл ахуйн дараах тусгай шаардлагыг мөрдөнө:

6.5.1.битүүмжилсэн тусгаарласан ажлын талбай руу орох хэсэгт “цэвэрлэгээний өрөө”-г байгуулна. Цэвэрлэгээний өрөө байгуулахад ус нэвтрүүлдэггүй 0.1524 мм зузаантай пластик материал ашиглана.

6.5.2.цэвэрлэгээний өрөө нь тоног төхөөрөмж, усанд орох, цэвэр тасалгаатай байна.

i.тоног төхөөрөмжийн тасалгаа нь ажлын байр луу орох хэсэгт байрлах ба дотор ажлын бохир хувцас, хамгаалах хэрэгслийг хийхэд зориулсан чийг, тоос нэвтрүүлдэггүй уут, сав байрлуулна.

ii.усанд орох тасалгаа нь тоног төхөөрөмжийн болон цэвэр тасалгаануудын дунд байрлана. Гадна байрлах ажлын байрны тухайд улирал, цаг уурын онцлогоос хамаарч усанд орох тасалгааг ашиглах боломжгүй бол ХЕПА шүүлтүүртэй тоос сорогчоор ажлын хувцсыг цэвэрлэж болно.

iii.цэвэр тасалгаанд ажилтны энгийн хувцас хадгалах шүүгээ байрлуулна.

6.5.3.цэвэрлэгээний өрөөгөөр дамжин ажлын байранд нэвтрэх дараалал. Ажилтан цэвэр тасалгаанд орж энгийн хувцсаа тайлж, шүүгээнд хийнэ. Ажлын хувцас, амьсгал хамгаалах хэрэгслийг өмсөж тоног төхөөрөмжийн тасалгаагаар дамжиж ажлын байранд нэвтэрнэ.

6.5.4.цэвэрлэгээний өрөөгөөр дамжин ажлын байрнаас гарах дараалал. Ажлын дараа ажилтан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн тоосыг ХЕПА шүүлтүүртэй тоос сорогчоор соруулж цэвэрлэсний дараа тоног төхөөрөмжийн тасалгаанд орж бохирдсон ажлын хувцсаа тайлж хийх шошго бүхий уут, савand хийнэ. Амьсгал хамгаалах хэрэгслээ тайлахгүйгээр усанд орох тасалгаанд усанд орж, амьсгал хамгаалах хэрэгслээ угаасны

дараа тайлж, бохирдсон шүүлтүүрийг хогийн уутанд хийнэ. Усан орсны дараа цэвэр тасалгаа руу орж энгийн хувцсаа өмсөж, гарна.

6.5.5.цэвэрлэгээний өрөө нь ус чиг нэвтрүүлдэггүй материалаар хийгдсэн байх ба шалыг нь битүүлсэн байна. Цэвэрлэгээний өрөө, тасалгаа нь бохирдлыг тараахгүйгээр ажилтан хувцсаа солих, тоног төхөөрөмжийг цэвэрлэх, усанд орох зэрэгт хангалттай зайтай байна.

Долоо. Асбестийн аюул, эрсдэлийн мэдээлэл

7.1.Барилга, байгууламж эзэмшигч, ашиглагч тухайн барилгад хэрэглэгдсэн асбест агуулсан материалыг тодорхойлж, тэдгээр материалын ерөнхий шинж, байрлал, тоон хэмжээг бүртгэсэн байна.

7.2.Барилга, байгууламжид эзэмшигч, ашиглагч нь засвар шинэчлэл хийхэд үед асбест агуулсан материалыг хөндөх эсвэл зайлуулах бол ажил гүйцэтгэх талд мэдэгдэж, ажил гүйцэтгэх ажилтан, бусад хүмүүсийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхааруулна.

7.3.Асбесттай харьцдаг ажил явагдаж байгаа барилга, ажлын байранд аюулыг мэдээлэх, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулж ажилтан, бусад хүмүүст анхааруулна.

7.3.1.асбестийн аюулыг мэдээлэх зорилгоор асбестийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө, асбесттай харьцах ажил барилгын аль байршилд ямар хугацаанд явагдахыг мэдээлэх самбар эсвэл зураг хуудсыг барилгын орох хаалга болон ажлын талбай руу орох хэсэгт байрлуулна.

7.3.2.асбесттай харьцдаг ажил хийгдэж байгаа талбай руу орох хэсэгт хүний нүдэнд харагдахуйцаар байдлаар дараах анхааруулах тэмдгийг байрлуулна

АСБЕСТ АЮУЛТАЙ
АСБЕСТ ХОРТ ХАВДАР ҮҮСГЭГЧ
ЗӨВХӨН ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХҮН НЭВТЭРНЭ

7.3.3.ажлын тусгай хувцас, амьсгал хамгаалах хэрэгсэл хэрэглэх шаардлагатай ажлын байранд дараах анхааруулах тэмдгийг байрлуулна.

АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС, АМЬСГАЛ ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ ӨМСӨЖ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ АЖЛЫН БАЙР

7.3.4.анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ нь ажил гүйцэтгэж байгаа ажилтан, барилга руу орж байгаа хүний эх хэл дээр, ойлгомжтой байдлаар бичигдсэн байна. Түүнчлэн дүрслэлээр илэрхийлэгдсэн байж болно.

7.3.5.ажлын явцад үүссэн асбест агуулсан бүх төрлийн хог хаягдал болон асбестаар бохирлогдсон хамгаалах хувцас, тоног төхөөрөмжийг хийсэн уут, савны шошго нь дараах мэдээллийг агуулсан байна.

АСБЕСТ АГУУЛСАН ТООСОНД ӨРТӨХ АЮУЛТАЙ
АСБЕСТ ХОРТ ХАВДАР ҮҮСГЭГЧ
АСБЕСТИЙН ТООС ДЭГДЭХЭЭС БОЛГООМЖИЛ

7.4. Асбесттай харьцах ажил хийдэг ажилтан нь энэ техникийн зохицуулалтын 8.2 дахь хэсэгт заасан агуулгаар сургалтад хамрагдаж, ажлыг аюулгүй гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, чадварыг эзэмшсэн байна.

Найм. Ажилтнуудад зориулсан сургалт, мэдээлэл

8.1.Асбесттай харьцдаг бүх ажилтан жил тутам сургалтад хамрагдаж, асбесттай харьцах ажлыг аюулгүй гүйцэтгэх мэдлэг, чадварыг эзэмшсэн байна.

8.2. Асбестийн аюулгүй ажиллагааны сургалт нь онол, дадлага хосолсон 24 цагаас багагүй багтаамжтай, дараах үндсэн агуулгатай байна:

8.2.1.асбестийн тоос үүсгэгч материал, ажиллагааг таних, эрсдэлийг үнэлэх арга;

8.2.2.асбестийн өртөлтөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө;

8.2.3.тамхины утаа болон асбестийн хамссан сөрөг нөлөө;

8.2.4.асбесттай харьцдаг ажлын ангилал, асбестийн өртөлтийг бууруулах инженерийн хяналтын арга хэмжээ, ажлын арга барил, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, эрүүл ахуйн дэглэм, цэвэрлэгээ, хог хаягдлын менежмент;

8.2.5.амьсгал хамгаалах хэрэгслийн зориулалт, зөв хэрэглэх арга, тохиромжтой байдал, хязгаарлалт;

8.2.6.асбестийн өртөлт бүхий ажил гүйцэтгэх үед мөрдөх зохих ажлын дадал, нойтон арга, агааржуулалтын зохистой ашиглалт;

8.2.7.ажилтны эрүүл мэндийн тандалт, хяналтын үзлэгт хамрагдах шаардлага;

8.2.8.энэхүү техникийн зохицуулалт, бусад стандартын шаардлагыг биелүүлэхэд заасан ажилтны эрх, үүрэг;

8.2.9.тамхинаас гарахад чиглэсэн мэдээлэл, зөвлөгөө

8.2.10.аюулыг мэдээлэх арга, тэмдэг, тэмдэглэгээ, анхааруулах бичгийн утга, хэрэглээ.

8.2.11.асбестийг хязгаарлалттай ашиглаж байгаа аж ахуйн нэгж байгууллага, салбарын онцлогт тохируулан асбесттай харьцах эрсдэлийн мэдээлэл, сургалт, практик дадал.

8.3.Сургалтын дүүргэж, шалгалтаар амжилттай дүүргэсэн ажилтанд Асбесттай харьцах аюулгүй ажиллагаагаар мэргэшсэн гэрчилгээг 1 жилийн хугацаатай олгох ба жил бүр давтан сургалтад хамруулна.

8.4.Асбесттай харьцах аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулахад тавигдах нийтлэг шаардлагыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын журмаар тогтооно.

Ес. Ажилтны эрүүл мэндийн тандалт

9.1.Асбесттай харьцдаг ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалтыг зохион байгуулахад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлсан эрүүл мэндийн үзлэгийн журмыг мөрдөнө.

9.2.Асбесттай харьцдаг ажилтныг ажилд авахаас өмнөх урьдчилсан болон ажилд орсны дараах хугацаат үзлэгт жил бүр хамруулна.

9.3.Эрүүл мэндийн хугацаат үзлэг нь асбестаар үүсгэгддэг мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хоёрдогч урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөнө.

9.4.Ажил олгогч нь ажилтны эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний баримтыг эрүүл мэндийн тандалт хийх зорилгоор бүртгэл үүсгэж хадгална.

9.6.Асбестийн өртөлтөөс үүдэлтэй мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг оношилсон эрүүл мэндийн байгууллага нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлсан мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх журмын дагуу мэргэжлийн өвчин судлал хариуцсан байгууллагад мэдээлж, бүртгүүлнэ.

9.7.Тоосоор үүсгэгддэг мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан ажилтныг насан туршид нь мэргэжлээс шалтгаалсан өвчний статистик бүртгэл, хяналтад байлгана.

_____o0o_____